

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24-ний өдөр

№01


Арвайхээр сум

Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Баянтээг” ХК-ийн 2018 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг батласугай.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ

“Баянтээг” ХК - ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлт

“Баянтээг” ХК –ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, “Баянтээг” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, дараах чиглэлүүдээр дүгнэлт өгч байна.

Хөрс хуулалт нүүрс борлуулалт:

Тус компани нь 2018 онд 350.0 мян/м3 хөрс хуулж, 130.0 мян/тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласанаас тус онд нийт 477.6 мян/м3 хөрс хуулж, 167.4 мян/тн нүүрс олборлон борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөөг 136.4%, нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 128.7%-иар давуулан биелүүллээ. Шилжих нүүрсний нөөц 89.6 мян.тн байна.

2018 онд нийт борлуулалтын орлого 3804.0 сая/төгрөгийн төлөвлөгөөтэй ажилласанаас нийт 5043.6 сая/төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийт зардал 3025.1 сая/төг-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд татвар төлөхийн өмнөх ашиг 2018.6 сая/төг байна.

Хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэл :

2018 онд 156.7 сая/төгрөгийн хөрөнгө оруулалат техникийн шинэчлэл хийсэн. 118.5 сая/төгрөгийн их засвар, 25.6 сая/төгрөгийн урсгал засвар хийж машин техник, тоног төхөөрөмийн бэлэн байдлыг хангаж сааталгүй ажилласан

Нийгмийн хариуцлагын хүрээнд

2018 он Хүүхэд хөгжил хамгаалалын жил болгон зарласантай холбогдон тус аяны хүрээнд 70.0 сая/төг, Нарийнтээл сум болон Баянтээг багийн төвд цэцэрлэг, эмнэлэгийн тохжилт тавилга эд хогшилд, уурхайчдын болон мал эмнэлэгийн сургалтуудыг зохион байгуулж 232.2 сая/төгрөгийг зарцуулж нийгмийн хариуцлагын хүрээнд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэсэн гэж үзэж байна

Цалин хөлс, үр ашиг:

2018 онд компани нь нийт 51 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж ажилчдын цалинг нэмэгдүүлээгүй бөгөөд ажиллагсдын дундаж цалин гүйцэтгэлээрээ 886.8 мян/төг байна. 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цэвэр ашиг 2018.6 сая/төгрөг байна.

Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ

Гүйцэтгэх захиралтай 2018 онд байгуулсан гэрээний биелэлтийг бүрэн хангаж биелүүлсэн, мөн “Баянтээг” ХК-ийн гүйцэтгэх захирал нь 2018 онд төлөвлөсөн зорилтоо өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан тул “Хангалттай” гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна

ДАРГА



О. БАТЖАРГАЛ

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24-ний өдөр

№02

Арвайхээр сум


Аудитын хорооны тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дах заалтыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Баянтээг” ХК-ийн Аудитын хорооны хавсралтаар гарсан дүгнэлтийг хангалтгүй гэж үзсүгэй.

2. “Баянтээг” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар шалгуулсугай.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ


2019 оны 04 сарын 24 өдөр

“Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4 дүгээр зүйлийн дагуу үйл ажилагаагаа явуулсан бөгөөд “Баянтээг” ХК-ний санхүүд 2018 оны 12 дугаар сарын 31 байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа.

“Баянтээг” ХК нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

“Баянтээг” ХК нь Өвөрхангай аймгийн Аудитын газраар гурван жил, 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-аар, 2016 оноос хойш “Дөлгөөн хайрхан уул аудит” ХХК-аар тус тус санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэжээ.

2018 оны байдлаар их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийгдээгүй гэж үзэв. Мөн гэрээ хэлцэлийг ашиггүй хийснээс болоод алдагдал хүлээгээгүй болно.

ДАРГА  З.ДАШЗЭВГЭ



“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24-ний өдөр

№03

Арвайхээр сум

ТУЗ болон Гүйцэтгэх захиралын зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дах заалтыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирлах зөвлөлийн гишүүдийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож, хуралд оролцсон тоогоор олгосугай.

2. Гүйцэтгэх захиралтай ТУЗ-ийн байгуулсан гэрээний дагуу үндсэн цалинг 2650000 төгрөгөөр, урамшуулалыг Төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг үндэслэн олгосугай.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24-ний өдөр

№04

Арвайхээр сум

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
 - 1) О.Батжаргал
 - 2) Ю.Батсайхан
 - 3) Г.Баясгалан
 - 4) И.Доржсүрэн
 - 5) Д.Миеэгомбо
 - 6) Д.Нэмэхбаяр
 - 7) Д.Энхбат
2. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 - 8) Г.Батсүх
 - 9) З.Дашзэвгэ
 - 10) Р.Өлзийжаргал
 - 11) Л.Энхбат нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ

БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24-ний өдөр

№05

Арвайхээр сум

Компанийн ногдол ашгийн тогтоолыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дах заалтыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 11 -ний өдрийн 04 дугаар тогтоолыг дэмжсүгэй.
2. Ногдол ашгийг 2019 оны 06 дугаар сарын 01 өдрийн дотор тараахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
"БАЯНТЭЭГ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 04

Баянтээг

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ


“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.3.13 дэх заалтын тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компани 2018 онд 2018,5 сая төгрөгний ашигтай ажилласан бөгөөд цэвэр ашгийн 49,5 % буюу нэгж хувьцаанд 3958,7 төгрөгөөр нийт 252,608 ширхэг хувьцаанд нийтдээ 1000000000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоосугай.

2.Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг компанийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөр , ногдол ашиг төлөх өдрийг 2019 оны 06 дугаар сарын 01–ний өдрөөр тогтоосугай.

3.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ногдол ашиг хуваарьлах тухай шийдвэрийг мэдэгдсүгэй.

ДАРГА



О.БАТЖАРГАЛ